

**ХОВД АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2021 ОНД АВИЛГЫН ЭСРЭГ
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХЭРХЭН ХАНГАН АЖИЛЛАСАН ТУХАЙ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2021 оны 10 дугаар сарын 26

Ховд аймаг

***Нэг. Авилгын эсрэг хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан талаар:
Мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа***

Тус хэлтсийн хэмжээнд Авилгын эсрэг хуулийн 7.1.6” Албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан хэтрүүлэх”, 7.1.7”албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах, давуу талаа ашиглан эрх эдлэх заалтуудыг зөрчсөн ямар нэгэн үйлдэл албан тушаалтнуудаас гаргаагүй болно.

Хоёр. Мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа

2021 онд шинээр албан тушаалд томилогдсон 3 албан тушаалтны урьдчилсан мэдүүлгийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлж хянуулан ХАСХОМ-ийг 30 хоногийн дотор гаргуулж цахим програмд шивлээ.

Мэдүүлгийн тайлан мэдээг үнэн зөв, хуулийн хугацаанд, маягтын дагуу, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хүлээн авсан тухай болон бусад бүртгэлийг бүрэн хөтөлсөн.

Хэлтсийн хэмжээнд төрийн жинхэнэ албан хаагч 33 албан тушаалтны ХАСХОМ-ийг хүлээн авч баталгаажуулалаа.

Гурав. Зөвлөмж болон сургалт, сурталчилгааны үйл ажиллагаа

Авлигын эсрэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар 44 албан тушаалтанд онлайн сургалт зохион байгуулсан.

17 сумын улсын бүртгэгч, хэлтсийн 23 албан хаагчдад онлайн сургалт, бүсийн сургалтанд зохих хуулийн чиглэлээр хичээл оруулсан.



17 сумын улсын бүртгэгч, хэлтсийн 23 албан хаагчдад онлайн сургалт, бүсийн сургалтанд зохих хуулийн чиглэлээр хичээл оруулсан.

“Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”, “Хариуцлагатай тунгалаг төр” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд хэлтсийн жилийн ажлын төлөвлөгөө гаргаж биелэлт тооцон ажилласан.

Дөрөв.Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

“Төсвийн тухай хууль”, “Шилэн дансны тухай хуулийг тухай бүр нь хэрэгжүүлэн ажиллах үүднээс төсөв санхүүтэй холбоотой ямар нэгэн алдаа зөрчил үүсгэлгүй ажиллах тал дээр анхааран ажиллаж 2021 оны батлагдсан төсвийн хүрээнд ямар нэгэн зөрчил дутагдал, өр авлага үүсгэлгүй ажилласан.

Улсын бүртгэгч нарын бүртгэлийн чиглэлээр үйлчилгээ үзүүлэхдээ иргэдэд олгож буй үнэт цаас, гэрчилгээ, үйлчилгээний хураамж, тэмдэгтийн хураамжийн тооцоог сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгон хүлээн авч үнэт цаасны тооцоог нь бодож ямар нэгэн өр төлбөр үүсгэх эрсдлээс нь хамгаалан ажиллаж байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилийг ханган ажиллах үүднээс шилэн дансны мэдээллийг байгууллагын цахим хуудсаар дамжуулан, мэдээллийг тогтмол шинэчлэн гаргаж хэвшсэн.

Дөрөв.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийн талаар:

Тус хэлтэс нь Япон улсын КОЙКА-н буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа “Улсын бүртгэлийн үйл ажиллагааг дэмжих” төслийн хүрээнд шинэчилсэн бүртгэлийн 18 ширхэг иж бүрэн тоног төхөөрмж, 1 ширхэг компьютер тоног төхөөрөмж, КОВИД-19 цар тахлаас хамгаалах ариутгалын хэрэгсэл, иж бүрэн цэвэрлэгээ үйлчилгээний түрдэг тэрэг хэрэгсэлийн хамт хүлээн авч үйл ажиллагаанда ашиглаж байна.

Тав. Зөвлөмж болон сургалт, сурталчилгааны үйл ажиллагаа

Авлигын эсрэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажиллах зорилгоор хяналтын улсын байцаагч нартай хамтран 5 сумын улсын бүртгэгч нарын 2020 оны бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн.Хэлтсийн даргын дэргэдэх ёс зүйн хороог байгуулан ажиллаж иргэдээс ирсэн гомдолын мөрөөр ёс зүйн зөрчил үүсгэсэн албан хаагчдыг хурлаар оруулан сануулах арга хэмжүүэ авч ажиллаж байна.

2021 оны байдлаар ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй ба Засгийн газрын 1111 төвийн утсаар 3 улсын бүртгэгчтэй холбоотой гомдол ирснийг шалган үзэж иргэдэд хариу агч ажилласан бөгөөд тухайн улсын бүртгэгч нартай холбоотой илт буруутай үйлдэл тогтоогдоогүй болно.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжийг нийт албан хаагчдад олшруулан түгээн ажилласан.

Шинээр томилогдсон албан тушаалтнуудад Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг танилцуулж хэвшсэн бөгөөд энэ талаар ямар нэгэн гомдол мэдээлэл ирээгүй

Цаашид Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр болон Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж, сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах болно.

ТАЙЛАН БИЧСЭН:
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ИРГЭНИЙ
УЛСЫН АХЛАХ БҮРТГЭГЧ

Б.ЭРДЭНЭБУЛГАН

ХЯНАСАН:
УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

С.ХОРОЛСҮРЭН